ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Г.Гүнжидмаа**
**Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn**
**Аудитор: Э.Энхбаатар**
**Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn**
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Дабль аксиом Аудит ХХК**
**Захирал: Т.Мягмарсүрэн**
**Утас: 99999957 Цахим хаяг: doubleaxiomaudit@gmail.com**

Улаанбаатар хот
2022 он

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 12
3. Аудитын тайлан ........ 13
3.1 Ерөнхий зүйл ........ 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14
3.4 Материаллаг байдал ........ 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 17
3.8 Аудитын гол асуудал ........ 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 18
3.9.3 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19
4. Аудитын илрүүлэлт ........ 20
4.1 Залруулсан алдаа ........ 20
4.2 Төлбөрийн акт ........ 20
4.3 Албан шаардлага ........ 20
4.4 Зөвлөмж ........ 21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 23

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/350
танай ____________-ны № ____________-т

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0224 Auditiin 2 Gazar-66.Docx

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,800,825,005.78** | **16,044,631,472.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **52,005,723.47** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | **52,005,723.47** |
| **3121** | **Төгрөг** | - | **52,005,723.47** |
| **33** | **АВЛАГА** | **67,326,928.41** | **9,150,812,630.58** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 175,202.77 | 678,798.13 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 3,576,000.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 60,255,074.33 | 9,035,448,115.69 |
| **335** | **Бусад авлага** | **3,320,651.31** | **114,685,716.76** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 3,320,651.31 | 114,685,716.76 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **5,733,498,077.37** | **6,841,813,118.47** |
| **351** | **Түүхий эд материал** | **1,799,020,521.71** | **2,137,097,638.95** |
| 35130 | Эм боох материал | 1,799,020,521.71 | 2,137,097,638.95 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,873,384,258.85 | 4,391,708,654.79 |
| **354** | **Хангамжийн материал** | **61,093,296.81** | **313,006,824.73** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,132,517.84 | 3,424,217.10 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,696,873.00 | 1,744,451.48 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 49,520,913.99 | 304,347,479.36 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,642,266.41 | 3,490,676.79 |
| 35450 | Барилгын засварын материал | 100,725.57 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **44,096,899,839.02** | **50,831,617,796.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **44,096,899,839.02** | **50,831,617,796.40** |
| **392** | **Биет хөрөнгө** | **43,210,474,317.80** | **49,964,210,557.03** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 25,297,563,870.49 | 25,528,683,929.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (852,326,251.08) | (1,287,402,326.00) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 204,386,416.00 | 204,386,416.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (181,750,097.60) | (190,979,762.95) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,508,145,860.35 | 61,471,644,643.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (31,444,073,317.69) | (36,373,461,799.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,033,592,876.26 | 1,069,498,726.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (462,365,166.72) | (561,372,455.48) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 284,216,791.71 | 291,311,791.71 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (176,916,663.92) | (188,098,605.34) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **886,425,521.22** | **867,407,239.37** |
| 39301 | Програм хангамж | 124,191,903.00 | 124,191,903.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (68,151,481.78) | (87,169,763.63) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 830,385,100.00 | 830,385,100.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **49,897,724,844.80** | **66,876,249,268.92** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **653,218,852.29** | **7,801,119,274.87** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **653,218,852.29** | **7,791,119,274.87** |
| **412** | **Богино хугацаат зээлийн өглөг** | **35,348,115.45** | **31,554,151.45** |
| **4121** | **Төгрөг** | **35,348,115.45** | **31,554,151.45** |
| 41211 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 35,348,115.45 | 31,554,151.45 |
| **413** | **Өглөг** | **617,870,736.84** | **7,759,565,123.42** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 55,852,913.54 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 34,165,577.60 | - |
| **4136** | **Бусад өглөг** | **583,705,159.24** | **7,703,712,209.88** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 583,705,159.24 | 7,703,712,209.88 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | | - |
| 41400 | **Урьдчилж орсон орлого** | - | **10,000,000.00** |
| 41400 | Бусад урьдчилж орсон орлого | - | 10,000,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **49,244,505,992.51** | **59,075,129,994.05** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **49,244,505,992.51** | **59,075,129,994.05** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 21,376,629,291.33 | 21,376,629,291.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 21,376,629,291.33 | 21,376,629,291.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **18,453,282,768.04** | **28,283,906,769.58** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 13,831,830,226.50 | 18,453,282,768.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 4,621,452,541.54 | 9,830,624,001.54 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 9,414,593,933.14 | 9,414,593,933.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **49,897,724,844.80** | **66,876,249,268.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **53,820,712,811.15** | **74,515,615,058.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,324,454,221.15** | **24,518,463,321.39** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **15,295,954,221.15** | **24,518,463,321.39** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,295,954,221.15 | 24,518,463,321.39 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,927,628,579.00 | 3,550,692,612.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,602,673,784.35 | 5,092,498,870.10 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 7,765,651,857.80 | 11,829,935,878.81 |
| 1200046 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 4,045,335,960.48 |
| **122** | **Тусламжийн орлого** | **28,500,000.00** | **-** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 28,500,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **38,496,258,590.00** | **49,997,151,736.69** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 14,507,014,200.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 14,507,014,200.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,066,000.00** | **11,196,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,066,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 11,196,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **23,985,178,390.00** | **49,985,955,736.69** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 23,985,178,390.00 | 49,985,955,736.69 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **49,199,260,269.61** | **64,684,991,056.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,199,663,056.95** | **64,684,991,056.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **48,787,385,122.95** | **63,555,412,060.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **12,919,211,314.07** | **17,750,655,776.59** |
| 210101 | Үндсэн цалин | 6,505,727,715.07 | 8,972,490,964.23 |
| 210102 | Нэмэгдэл | 4,767,724,682.00 | 7,013,333,285.36 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 884,855,625.00 | 1,113,236,873.00 |
| 210104 | Урамшуулал | 760,903,292.00 | 651,594,654.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,652,568,693.54** | **2,354,043,178.18** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,137,101,182.97 | 1,662,901,090.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 140,529,178.93 | 178,660,673.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 102,007,138.02 | 139,017,487.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 25,191,388.78 | 33,618,301.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 247,739,804.84 | 339,845,624.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **933,246,606.63** | **1,170,191,039.08** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 539,802,836.36 | 552,995,179.13 |
| 210302 | Түлш, халаалт | 175,301,684.80 | 239,317,418.39 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 218,142,085.47 | 377,878,441.56 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **998,132,019.89** | **717,145,533.46** |
| 210401 | Бичиг хэрэг | 188,268,072.16 | 105,727,565.74 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,997,770.30 | 38,409,095.97 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,021,862.96 | 27,495,739.39 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,151,753.45 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 738,624,211.02 | 541,295,562.35 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,068,350.00 | 4,217,570.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,567,242,204.47** | **34,449,557,374.47** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,970,930,204.47 | 33,727,186,874.47 |
| 210502 | Хоол, хүнс | 596,312,000.00 | 722,370,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **618,075,374.16** | **642,665,871.50** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,100.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 618,066,274.16 | 642,665,871.50 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,839,100.00** | **36,111,400.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 25,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,839,100.00 | 11,111,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **303,633,750.00** | **436,990,296.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 286,688,600.00 | 403,927,092.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,900,000.00 | 9,900,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,167,440.00 | 4,294,056.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 492,260.00 | 488,108.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 13,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,385,450.00 | 5,381,040.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,787,436,060.19** | **5,998,051,591.27** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 497,063,121.20 | 495,149,856.84 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,290,372,938.99 | 5,502,901,734.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **412,277,934.00** | **1,129,578,996.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **408,211,934.00** | **1,129,578,996.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 252,516,054.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 153,267,880.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,428,000.00 | 1,129,578,996.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,066,000.00** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,066,000.00 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **(402,787.34)** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **(402,787.34)** | **-** |
| 223001 | Бусад хөрөнгө | (402,787.34) | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,621,452,541.54** | **9,830,624,001.54** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **-** |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,621,452,541.54** | **9,830,624,001.54** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 13,831,830,226.50 | 44,623,053,450.97 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 13,831,830,226.50 | 44,623,053,450.97 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 4,621,452,541.54 | 4,621,452,541.54 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 18,453,282,768.04 | 49,244,505,992.51 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 18,453,282,768.04 | 49,244,505,992.51 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 9,830,624,001.54 | 9,830,624,001.54 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 28,283,906,769.58 | 59,075,129,994.05 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 46,267,290,002.05 | 49,537,131,154.34 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,734,758,602.05 | 8,586,623,533.34 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,734,758,602.05 | 8,586,623,533.34 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,734,758,602.05 | 8,586,623,533.34 |
| 1200041 | Төсөв байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 5,904,779,273.91 | 3,692,087,940.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,829,979,328.14 | 4,894,535,593.34 |
| 122 | Тусламжийн орлого | 28,500,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 28,500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 38,504,031,400.00 | 40,950,507,621.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 14,507,014,200.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 14,507,014,200.00 | - |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | 1,190,000,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,066,000.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,066,000.00 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 23,992,951,200.00 | 39,760,507,621.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 23,992,951,200.00 | 39,760,507,621.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 43,623,804,476.27 | 49,087,316,617.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 43,623,804,476.27 | 49,087,316,617.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 43,153,548,567.94 | 47,957,449,621.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 12,695,290,300.00 | 17,436,952,457.86 |
| 210101 | Үндсэн цалин | 7,410,082,100 | 8,904,783,330 |
| 210102 | Нэмэгдэл | 3,811,188,200 | 6,727,824,558 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 866,250,000 | 915,650,850 |
| 210104 | Урамшуулал | 607,770,000 | 888,693,719 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,669,205,400.00 | 2,330,041,118.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,242,689,200 | 1,766,680,328 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 106,629,100 | 140,840,368 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 85,303,200 | 112,672,067 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,325,800 | 28,168,240 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 213,258,100 | 281,680,116 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 937,786,800.00 | 1,177,552,303.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 536,986,633 | 552,995,179 |
| 210302 | Түлш, халаалт | 185,717,204 | 243,111,382 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 215,082,963 | 381,445,742 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 316,704,491.96 | 353,597,919.39 |
| 210401 | Бичиг хэрэг | 51,846,545 | 31,639,730 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,063,000 | 33,500,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 21,621,863 | 28,997,450 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгдийн устгал, ариутгал | 184,547,529 | 207,095,960 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,625,555 | 52,364,780 |
| 2105 | Нормативт зардал | 17,501,901,010.14 | 25,056,181,653.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,793,800,618 | 24,419,403,153 |
| 210502 | Хоол, хүнс | 627,347,892 | 602,889,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 80,752,500 | 33,889,500 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,151,976,564.84 | 449,489,097.78 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 491,868,286 | 74,848,039 |
| 210602 | Тавилга | 44,915,540.00 | 19,330,746.00 |
| 210604 | Урсгал засвар | 615,192,739 | 355,310,312 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,527,200.00 | 39,117,600.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | 32,278,400 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,527,200 | 6,839,200 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 328,448,020.00 | 335,002,695.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 286,363,370 | 284,530,491 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,900,000 | 9,900,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,453,640 | 4,294,056 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 655,560 | 488,108.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,200,000 | 13,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,385,450 | 5,381,040.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 22,440,000 | 17,409,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,548,708,781.00 | 779,514,777.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,548,708,781 | 779,514,777 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 470,255,908.33 | 1,129,866,996.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 405,934,834 | 1,129,866,996 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,689,134 | 1,129,866,996 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 395,245,700 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 64,321,074.33 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,321,074.33 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 2,643,485,526.00 | 449,814,536.47 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,677,775,646.00 | 397,808,813.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,677,775,646.00 | 397,808,813.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,677,775,646.00 | 397,808,813.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,677,775,646.00 | 397,808,813.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (2,677,775,646.00) | (397,808,813.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (34,290,120.00) | 52,005,723.47 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 34,290,120.00 | (0.00) |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | (0.00) | 52,005,723.47 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 57,290,868,800.00 | 49,485,125,430.87 | (7,805,743,369.13) | 86.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 57,290,868,800.00 | 49,485,125,430.87 | (7,805,743,369.13) | 86.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 56,159,968,800.00 | 48,355,258,434.87 | (7,804,710,365.13) | 86.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 17,436,952,500.00 | 17,436,952,457.86 | (42.14) | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 12,040,619,000.00 | 8,904,783,330.10 | (3,135,835,669.90) | 74.0 |
| 210102 | Нэмэгдэл | 3,545,496,000.00 | 6,727,824,558.19 | 3,182,328,558.19 | 189.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 866,250,000.00 | 915,650,850.43 | 49,400,850.43 | 105.7 |
| 210104 | Урамшуулал | 984,587,500.00 | 888,693,719.14 | (95,893,780.86) | 90.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,330,041,200.00 | 2,330,041,118.70 | (81.30) | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,851,631,200.00 | 1,766,680,327.70 | (84,950,872.30) | 95.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 119,602,500.00 | 140,840,368.00 | 21,237,868.00 | 117.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 95,682,000.00 | 112,672,066.60 | 16,990,066.60 | 117.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 23,920,500.00 | 28,168,240.40 | 4,247,740.40 | 117.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 239,205,000.00 | 281,680,116.00 | 42,475,116.00 | 117.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,177,552,300.00 | 1,177,552,303.08 | 3.08 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 552,995,200.00 | 552,995,179.13 | (20.87) | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 243,111,400.00 | 243,111,382.39 | (17.61) | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 381,445,700.00 | 381,445,741.56 | 41.56 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 367,241,700.00 | 354,807,919.39 | (12,433,780.61) | 96.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 37,943,100.00 | 31,639,729.80 | (6,303,370.20) | 83.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,862,800.00 | 33,500,000.00 | 637,200.00 | 101.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,198,800.00 | 28,997,449.59 | 1,798,649.59 | 106.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 213,209,600.00 | 207,095,960.00 | (6,113,640.00) | 97.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 56,027,400.00 | 53,574,780.00 | (2,452,620.00) | 95.6 |
| 2105 | Нормативт зардал | 32,358,668,000.00 | 25,056,181,653.00 | (7,302,486,347.00) | 77.4 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,554,930,100.00 | 24,419,403,153.00 | (7,135,526,947.00) | 77.4 |
| 210502 | Хоол, хүнс | 685,561,600.00 | 602,889,000.00 | (82,672,600.00) | 87.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 118,176,300.00 | 33,889,500.00 | (84,286,800.00) | 28.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,228,026,200.00 | 841,053,110.78 | (386,973,089.22) | 68.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 341,177,200.00 | 181,144,739.49 | (160,032,460.51) | 53.1 |
| 210602 | Тавилга | 54,827,700.00 | 48,096,596.00 | (6,731,104.00) | 87.7 |
| 210604 | Урсгал засвар | 832,021,300.00 | 611,811,775.29 | (220,209,524.71) | 73.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 47,980,400.00 | 39,117,600.00 | (8,862,800.00) | 81.5 |
| 210701 | Гадаад томилолт /арга хэмжээ/ | 32,278,400.00 | 32,278,400.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,702,000.00 | 6,839,200.00 | (8,862,800.00) | 43.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 383,820,800.00 | 335,002,695.00 | (48,818,105.00) | 87.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 319,854,200.00 | 284,530,491.00 | (35,323,709.00) | 89.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,900,000.00 | 9,900,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,303,500.00 | 4,294,056.00 | (9,444.00) | 99.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 516,500.00 | 488,108.00 | (28,392.00) | 94.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 143,000.00 | - | (143,000.00) | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,320,000.00 | 13,000,000.00 | (3,320,000.00) | 79.7 |
| 210807 | Газрын төлбөр | 5,372,600.00 | 5,381,040.00 | 8,440.00 | 100.2 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 27,411,000.00 | 17,409,000.00 | (10,002,000.00) | 63.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 829,685,700.00 | 784,549,577.06 | (45,136,122.94) | 94.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 829,685,700.00 | 784,549,577.06 | (45,136,122.94) | 94.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,130,900,000.00 | 1,129,866,996.00 | (1,033,004.00) | 99.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,130,900,000.00 | 1,129,866,996.00 | (1,033,004.00) | 99.9 |
| 213204 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 1,130,900,000.00 | 1,129,866,996.00 | (1,033,004.00) | 99.9 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 57,290,868,800.00 | 49,537,131,154.34 | (7,753,737,645.66) | 86.5 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 50,116,313,500.00 | 40,950,507,621.00 | (9,165,805,879.00) | 81.7 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 50,116,313,500.00 | 39,760,507,621.00 | (10,355,805,879.00) | 79.3 |
| 134003 | Эрүүл мэндийн даатгалын нэмэлт санхүүжилтийн сангаас олгосон санхүүжилт | - | 1,190,000,000.00 | 1,190,000,000.00 | - |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 7,174,555,300.00 | 8,586,623,533.34 | 1,412,068,233.34 | 119.7 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,246,365,700.00 | 3,692,087,940.00 | 445,722,240.00 | 113.7 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,928,189,600.00 | 4,894,535,593.34 | 966,345,993.34 | 124.6 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 52,005,723.47 | 52,005,723.47 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 11,196,000.00 |
| 21 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 11,196,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 11,196,000.00 |
| 300011 | Орлого төвлөрүүлэх | - | 11,196,000.00 |
| 13 | Татаас санхүүжилтийн орлого | - | 11,196,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 9,532,000.00 |
| 131103 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,664,000.00 |
| 131107 | Урд оны үлдэгдлээс санхүүжих нэмэлт | - | - |
| 300002 | Нэр данс зөрүү | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, хууль эрх зүй, тогтоол шийдвэр, журам зааврын зөрчилтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно

Аудитыг 2022 оны 09 дүгээр сарын 27-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Дабль аксиом Аудит ХХК-ийн аудитор Д.Отгонжаргал, аудиторын туслах Б.Бат-Оргил, Б.Отгонтуяа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг менежер Э.Энхтуяа, захирал Т.Мягмарсүрэн нар хэрэгжүүлсэн.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/113 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үйлчилгээний соёл, анагаах ухааны шинэ технологи, инновацыг эрхэмлэгч, шилдэг багийн тогтолцоотой олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох зорилт дэвшүүлэн ажилладаг байна.

Тус эмнэлэг нь зорилгоо эмчилгээ, сувилгаа, үйлчилгээ, орчны шинэчлэлийг олон улсын түвшинд нийцүүлэн сайжруулж, инновац, эрдэм шинжилгээ, судалгааны хамрах хүрээг өргөжүүлэн, эмнэлгийн мэргэшсэн, нэгдмэл, цогц тусламж, үйлчилгээг салбарын анхдагч, үндэсний манлайлагчаас дэлхийн жишигт хүргэхэд оршино гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.4. "батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон цалингийн санд багтаан ажилтны ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, ажилтны нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадваржуулах";
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам" шинэчлэн батлах тухай;
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 67/А268 тоот тушаал. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ" батлах тухай;
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 6 дүгээр сарын 21-ны өдрийн А/387/99 тоот тушаал "Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн" батлах тухай;
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/257 дугаар тушаал "Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэл батлах тухай";
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус эмнэлэг нь нягтлан бодох бүртэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагаанд мөрддөг хуулиудын нэмэлт өөрчлөлтийг тусган шинэчлээгүй боловч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг”-ыг мөрдсөн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 онд 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд шалгалт хийж, шалгалтаар нийт 143,079.0 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг арилгаж ажиллах даалгавар өгсөн байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн үед 2020 оны, гүйцэтгэлийн үед 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын 49,199,260.3 мянган төгрөгөөс 2 хувь буюу 983,985.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын төлөвлөлтийн явцад 2020 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын үзүүлэлтээр тооцоолсон тул гүйцэтгэлийн явцад дахин хянаж 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 64,612,355.5 мянган төгрөгөөс 2 хувь буюу 1,292,247.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тогтоолоо.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,978,524.4 мянган төгрөгөөр буюу 34 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /Мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 52,005.7 | 52,005.7 |
| Авлага | 67,326.9 | 9,150,812.6 | 9,083,485.7 |
| Бараа материал | 5,733,498.1 | 6,841,813.1 | 1,108,315.0 |
| Үндсэн хөрөнгө | 44,096,899.8 | 50,831,617.8 | 6,734,718.0 |
| **Нийт хөрөнгө** | **49,897,724.8** | **66,876,249.2** | **16,978,524.4** |
| Өр төлбөр | 653,218.8 | 7,801,119.2 | 7,147,900.4 |
| Засгийн газрын оролцоо | 49,244,506.0 | 59,075,130.0 | 9,830,624.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **49,897,724.8** | **66,876,249.2** | **16,978,524.4** |

Дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 52,005.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төв төрийн санд татан төвлөрүүлээгүй;
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 9,083,485.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМДЕГ-аас нэхэмжилсэн тусламж үйлчилгээний 9,035,448.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу, 25,385.0 мянган төгрөгийн түрээсийн орлогын авлага, 55,306.0 мянган төгрөгийн гэрэл цахилгааны орлогын авлага, 23,620.0 мянган төгрөгийн Их шүүдэргэнэ импорт ХХК-ийн ашиглалтын төлбөрийн авлагаар нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 1,108,315.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, дэлхийн банкны төслийн хүрээнд хүлээн авсан жижиг багаж хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс, Орбис төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хиймэл нүдний хараа шалгах аппарат, Улсын нэгдүгээр эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ажилчдын амрах өрөөг тохижуулсан үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсээр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл ЭМЯ-ны хандиваар нийлүүлэгдсэн машин тоног төхөөрөмжийн дүнгээр нэмэгдсэн;
- Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 7,147,900.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМДЕГ-аас авах санхүүжилтийг бүрэн аваагүйгээс эмийн өглөг 7,301,510.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,830,624.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой өсөлт;

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20,694,902.3 мянган төгрөгөөр өссөн байна. Хандив тусламж, хөрөнгө оруулалтаар 8,109,620.0 мянган, туслах үйл ажиллагааны орлого 3,489,825.1 мянган, тусламж санхүүжилтийн орлого 11,493,763.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Энэ нь үндсэн тусламж үйлчилгээний орлого, нэмэлт тусламж үйлчилгээний орлого, Коронавирус халдвар (COVID-19)-ын цар тахлын үед Засгийн газрын хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн үзүүлсэн хандив тусламж болон Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 15,485,730.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс дараах материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Үндсэн болон нэмэгдэл цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 5,532,918.9 мянган төгрөгөөр өссөн нь бүх ажилтнуудад хандлагын нэмэгдэл 20 хувь, албан тушаал ахисан өөрчлөлт, шинээр нэвтрүүлсэн эмчилгээ, мэс ажилбар хийдэг

нарийн мэргэшлийн өндөр ур чадвартай эмч нарын цалингийн зэрэглэлийг ахиулсан зэргээс 130 ажилтны үндсэн цалинг 7-32 хувиар тус тус нэмэгдүүлсэн;

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 236,944.4 мянган төгрөгөөр өссөн;
- Бусад бараа үйлчилгээний зардал 8,882,315.2 мянган төгрөг нэмэгдсэн нь диализ, үндсэн тусламж үйлчилгээний эмийн зардал, Ковид-19 цар тахлаас шалтгаалан хэвтэн эмчлүүлэгчдийн болон шөнө ажилласан ажилчдын хоолны зардал 126,058.0 мянган, Ковид-19 цар тахалтай холбоотой эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт нэмж хийгдсэн нь нөлөөлсөн;
- Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 133,356.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эмнэлгийн дотоод сүлжээнээс UPTODATE системд холбогдон мэдээлэл технологийн цахим платформын хэрэглээний сүлжээ сайжруулалт хийгдсэн;
- Бусад урсгал шилжүүлэг 717,301.1 мянган төгрөгөөр өссөн нь Коронавируст халдвар (COVID-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496, А/585 дугаар тушаалуудаар 1,050,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, Коронавируст халдварын эрсдэлтэй, голомтот бүсэд ажиллаж байгаад халдвар авсан эрүүл мэндийн ажилтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/298 дугаар тушаалын дагуу эмнэлгийн ажилтнуудад 58,400.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн;

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарцуулалтыг 68,690,891.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 26,813,216.7 мянган төгрөгөөр бууруулан 41,877,675.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 2021 оны төсөвт 5 удаа тодотгол хийж, 11,400,023 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 57,290,868.8 мянган төгрөгөөр баталж, 50,116,313.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 7,174,555.3 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 40,985,955.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон бусад орлогоос 11,196.0 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны 8,643,191.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, ЭМДС-ийн санхүүжилт 81.7 хувийн, өөрийн үйл ажиллагааны орлого 119.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт зардлын гүйцэтгэл 49,485,125.4 мянган төгрөг буюу 86.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 48,818.0 мянган, бараа үйлчилгээний урсгал зардлыг 45,136.1 мянган, нормативт зардлыг 7,302,786.3 мянган, эд хогшил худалдаж авах зардлыг 386,973.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэг дэлгэн ажиллуулах түр журам”-ыг баримтлан ковидтой иргэдэд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн удирдах зөвлөл, Ерөнхий захирал болон түүний дэргэдэх Захирлын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Захирлын ажлын алба, Захиргаа, хүний нөөцийн алба, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, Санхүү бүртгэлийн алба гэсэн бие даасан албадаас бүрдэх бөгөөд өөрсдийн чиг үүргийн хүрээнд ажлаа зохион байгуулан ажилладаг байна.

Тус эмнэлэг иргэдэд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 2021 оны 3 дугаар сараас эхлэн ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжигдэх болсонтой холбогдуулан нэхэмжилсэн санхүүжилтээс ЭМДЕГ-ын хяналтаар 2,824,626.1 мянган төгрөгийн санхүүжилт баталгаажаагүй хасагдсан байна.

Хүснэгт 2. Баталгаажаагүй хасагдсан орлогыг төрлөөр нь нэгтгэн дараах хүснэгтээр харуулбал: /мянган төгрөгөөр/

| № | Тусламж үйлчилгээ | Нэхэмжилсэн дүн | Баталгаажсан дүн | Хасагдсан дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Амбулатори-өвчний учир үзлэг | 4,349,485.1 | 3,916,842.9 | 432,642.2 |
| 2 | Өндөр өртөгт оношилгоо | 3,636,095.2 | 3,496,904.0 | 139,191.3 |
| 3 | Өдрийн эмчилгээ | 45,371.2 | 39,276.1 | 6,095.1 |
| 4 | Сэргээн засах | 33,610.0 | 33,140.0 | 470.0 |
| 5 | Уламжлалт | 48,280.0 | 47,735.0 | 545.0 |
| 6 | Хэвтүүлэн эмчлэх | 24,909,234.0 | 24,013,147.5 | 896,086.5 |
| 7 | Яаралтай тусламж | 2,491,790.0 | 2,282,955.0 | 208,835.0 |
| 8 | Дуудлага | 20,637.9 | 17,510.9 | 3,127.0 |
| 9 | Диализ | 4,409,600.0 | 4,395,285.0 | 14,315.0 |
| 10 | Хэвтүүлэн эмчлэх-ковидын тохиолдол | 6,945,305.0 | 6,035,605.0 | 909,700.0 |
| 11 | Дархлаа дарангуйлах эм | 3,052,676.5 | 3,006,252.4 | 46,424.1 |
| 12 | Тандалтын ПСР шинжилгээ | 580,000.0 | 529,450.0 | 50,550.0 |
| 13 | Сорьц цуглуулах | 127,740.0 | 11,095.0 | 116,645.0 |
| | **Нийт дүн** | **50,649,824.8** | **47,825,198.7** | **2,824,626.1** |

ЭМДҮЗ-ийн баталсан 03 дугаар тогтоол, хамтын төлбөрийн зөрүү, программын шинэчлэл, нэвтрэлттэй холбоотой алдаа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 10 дугаар сараас иргэний сүүлийн 5 жилийн эрүүл мэндийн даатгалын төлөлтийг шалгаж төлөөгүй иргэдийн төлбөрийг хасаж тооцохдоо бүтэн жилээр нь хасалт хийсэн, даатгалын эмчийн шалтгаан тодорхой бус хасалт, эмчийн онош, үйлдлийн кодын алдаа зэргээс шалтгаалжээ. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмчийн тавьсан онош буюу үйлдлийн кодын алдаанаас шалтгаалж 168,699.2 мянган төгрөг хасагдсан байна.

Улаан бүсэд ковид-19 өвчнөөр хэвтэн эмчлүүлэгчдээс түүвэрлэн 71 өвчтөний эмчилгээний хуудсыг дүн бүртгэлтэй тулгалт хийн, 6 дугаар сард хэвтэн эмчлүүлсэн 32 өвчтөний эмийн зардлыг эм тараах хуудаснаас, бусад зардлыг журналаас тулган нэг өвчтөнд ногдох дундаж зардлыг тооцоолон гаргаж, зарцуулалтыг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/387/99, 67/А/268/ тушаалаар баталсан тарифтай харьцуулан үзэхэд өвчтөний биеийн байдал, хавсарсан өвчнөөс шалтгаалаад харилцан адилгүй байгаа боловч баталсан тарифаас харьцангуй бага байна.

### 3.8 Аудитын гол асуудал

ЭМДЕГ-аас хянан баталгаажуулсан санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс 9,035,448.1 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалттай холбоотой 7,682,382.6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Эрүүл мэндийн яамтай жилийн эцсийн тооцоо нийлэлтээр Эрүүл мэндийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны А/19 дүгээр тушаалыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны А/454 тушаалаар хүчингүй болгож, уг тушаалыг 2022 онд А/454 дүгээр тушаалтай нэгтгэн шинэчлэн гаргахдаа зарим нэр төрлийн хөрөнгийн нэгж үнэнд өөрчлөлт оруулсан нь өмнө орлогод авч бүртгэлд тусгасан дүнгээс 5,942.7 мянган төгрөгөөр дутуу, бага үнэтэй түргэн элэгдэх эд

зүйлсийн бүртгэлд 16,132.3 мянган төгрөгөөр өсч, нийт 10,189.6 мянган төгрөгийн үнийн зөрүү үүссэнийг залруулсан боловч уг тушаалыг эцэслэн баталж ирүүлээгүй.

2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч, орлогоор бүртгэсэн 94,050.0 мянган төгрөгийн эмийг хүлээн авах шийдвэр нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний А/822 тоот тушаалаар баталгаажсаныг 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны А/668 тушаалыг 2022 оны 1 дүгээр сард ирүүлсэн боловч 142,500.0 мянган төгрөгийн эмийг 2022 оны 2 дугаар сард хүлээн авч, тайлант хугацаанд орлогод авснаар санхүүгийн тайланд нэмэлт залруулга хийсэн байна.

Аудитыг хийж гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 1542 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2021 онд нийт 116,451,370.9 мянган төгрөгийн 1542 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15,640,519.6 мянган төгрөгийн 94 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/53 тоот тушаалаар Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хамт олныг төлөөлөх гишүүнээр тус эмнэлгийн аж ахуй, үйлчилгээний албаны даргыг 3 жилийн хугацаагаар томилон батламжилсан боловч Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн Б/496 тоот тушаалаар 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс тус эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь хамт олны төлөөлөх гишүүний албан тушаал өөрчлөгдсөнтэй холбогдуулан гишүүнээс чөлөөлж, шинэ гишүүнийг томилох ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 “*эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журмыг батлах*”, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйл. 15.1.1. “*тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй*”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3. "*ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг*, 3.1.4. "*нийтийн албан тушаалтан гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг*”, 8 дугаар зүйл 8.2. “*Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий*

*байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй*" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцэд өөрчлөлт оруулах ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж, хамт олныг төлөөлөх гишүүнийг шинэчлэн томилох, зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээлэл нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тус эмнэлгийн ахлах нягтлан бодогч бөгөөд санхүүгийн албаны дарга нь Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч мэргэшсэн нягтлан бодогч байна гэсэн шалгуурыг хангахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3. "*Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно*", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан "*Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур хангах журам*"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур, шаардлагыг хангаж ажиллах, зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Улсын нэгдүгээр төв ерөнхий нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуурын мэдээлэл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.3 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитаар нийт 2,903,596.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 806,767.7 мянган төгрөгийн 11 алдааг залруулж, 2,090,981.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг жилийн эцсийн аудитаар дахин хянаж үзэхээр шийдвэрлэсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 524.6 мянган төгрөгийн илүү олгосон зөрчилд тогтоосон 1 төлбөрийн акт болон 209,552.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлж, 500,905.9 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 91.6 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/Мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 524.6 | 1 | 524.6 | - | - | 100 |
| Албан шаардлага | 1 | 209,552.7 | 1 | 209,552.7 | | | 100 |
| Зөвлөмж | 6 | 500,905.9 | 6 | 500,905.9 | | | 91.6 |
| **Нийт дүн** | **8** | **710,983.2** | **8** | **710,983.2** | | | **97,2** |

### 3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМЯ-наас хуваарилсан хөрөнгө болон ЭМДЕГ-аас санхүүжүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээний орлогыг дараагийн аудитаар авч үзэж шаардлагатай.

Тайлант онд 7,973.2 мянган төгрөгийн үнэтэй Хяналтын монитор /IMEC-12/ 2 ширхгийг хүлээн авч орлогод бүртгэсэн боловч ЭМЯ-аас хөрөнгө хуваарилсан шийдвэр эцэслэн гараагүй байна. ЭМЯ-аас нийлүүлж байгаа бараа материал, хөрөнгийн үнэ харьцангуй өндөр үнэтэй байгаа болон ЭМДЕГ нь тусламж үйлчилгээний төлбөрийг нотлох баримтгүйгээр хасаж буй нь гүйцэтгэлээр санхүүжигч байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 716,675.8 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 355,940.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1,404.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 349,984.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 9,346.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 6 зөрчлийн дүн 360,735.4 мянган төгрөг нь шинэчлэн тогтоосон ерөнхий материаллаг байдал 1,292,247.1 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ЭМЯ-аас өмнөх тушаал шийдвэрээ шинэчлэн гаргахдаа зарим нэр төрлийн нэгж үнэд өөрчлөлт оруулсан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэмж орлого авсан нийт 152,689.6 мянган төгрөгийн зөрүү үүссэн;
- Амбулаторийн эмийн сангийн материалын товчоо тайланд 73 ширхэг эмийн үлдэгдлийг 303.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- ЭМДЕГ-аас 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн тулган баталгаажуулалтын хариу захидалд өмнө нь тусламж үйлчилгээний орлогын баталгаажуулсан авлагын үлдэгдлийг 202,946.9 мянган төгрөгөөр хасалт хийж тайлагнасан;

### 4.2 Төлбөрийн акт

Үйлчлүүлэгчид олгох 650.6 мянган төгрөгийн эмийг олгоогүй, зардалд бүртгэсэн, үйлчилгээ аваагүй үйлчлүүлэгчдийн үйлчилгээний төлбөрийг буцаахдаа үнийн дүнгээс 754.1 мянган төгрөгийн суутгал хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.4. "*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.11. "*өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах*", Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 тоот тушаалын гуравдугаар хавсралт “Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам”-ын 2.3. "*Иргэн өөрийн хүсэлтээр нэмэлт тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, алдангигүйгээр буцаан олгож баримтжуулна*" гэсэн заалтуудыг зөрчиж, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт 1,404.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Тайлант онд 13,182,633.3 мянган төгрөгийн худалдан авалтын 148 гэрээний биелэлт, хэрэгжилтийг ерөнхий журнал болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад гэрээний 92.1 хувийг дүгнээгүй, 99,018.0 мянган төгрөгийн 3 гэрээний нийлүүлэлт хийгдээгүй, 59,248.7 мянган төгрөгийн 7 гэрээ бүрэн биелээгүй байхад биелснээр акт үйлдсэн, 130,866.9 мянган төгрөгийн 26 гэрээ бүрэн хэрэгжээгүй, 51,419.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх 7 гэрээний дүнгээс илүү нийлүүлэлт хийсэн зэрэг нийт 43 гэрээний хэрэгжилт, бүртгэлтэй холбоотой нийт 340,552.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Харьцуулалтын аргаар 9,432.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ гэрээний үнээс өндөр үнээр болон үнийн саналд тусгасан үйлдвэрлэгч улс, нэгж үнийг зөрүүтэй гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан*

*авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*", гэрээний гэрээний 2.5, 2.6, 2.8 дугаар заалтуудыг мөрдөж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 “*энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх*”, 49 дүгээр зүйл 49.2.10 “*гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг*” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, үр дүнг тайланд тусгах, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээнд заасан хариуцлага тооцох, гэрээнд тусгасан үйлдвэрлэгчийн нэр болон үнээр худалдан авалт хийх, албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Дотоод аудиттай холбоотой асуудал**

<u>Илрүүлэлт:</u>

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, төсөв төлөвлөлтийг эдийн засгийн албанаас бүрэн бэлтгэж төлөвлөөгүй, мэдээлэл дутагдалтай, эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрт дотоод аудит болон дотоод хяналтын талаар тусгагдсан, авсан арга хэмжээний талаар тэмдэглэсэн зүйл байхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u>

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. 19.1 ”*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*”, Төсвийн тухай хуулийн 16.5.6. "*дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*" Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.3. "*Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна*" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

**ЭМДЕГ-ын санхүүжилттэй холбоотой асуудал**

<u>Илрүүлэлт:</u>

ЭМДЕГ-аас олгосон санхүүжилтийг нэхэмжилсэн дүнтэй тулган шалгахад тодорхой шалтгаануудын улмаас баталгаажаагүй хасагдсан орлого байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны “*Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам*” шинэчлэн батлах тухай 03 дугаар тогтоолыг баримтлан ажиллаагүй, байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u>

Өвчтөний оношийг тогтоолын дагуу тавьж, тусламж үйлчилгээ үзүүлсэн зардлыг цахим мэдээллийн санд үнэн зөв мэдээлж, ЭМДЕГ-аас нэхэмжилж, төлбөр тооцоог тухай бүр нь тулган баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдэж байх.

**Албан томилолттой холбоотой асуудал**

<u>Илрүүлэлт</u>:

Алсын дуудлагын томилолтыг анхан шатны баримтаас түүвэрлэн давтан тооцоолол хийхэд албан томилолтын хуудсанд бичигдсэн ирсэн, явсан хоногийг тооцохдоо 1 хоног хасаагүй, ирсэн явсан өдрийг засварласан, дуудлагын хуудсанд бичигдсэн огноо зөрүүтэй, зарим үед хоногийг дутуу тооцсоноос 864.0 мянган төгрөгийн зөрчил гарсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4. "*Үнэн зөв байх*" гэсэн заалтыг мөрдөөгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан томилолтоор ажилласан тохиолдолд томилолтоор ажилласан албан тушаалтнаар мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулж, анхан шатны үнэн зөв баримтад үндэслэн гүйцэтгэлийг хянаж, үр дүнг тооцож байх

**Жижиг мөнгөн сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сангийн тайланд худалдан авагч болон бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэр бичигдээгүй баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, жижиг мөнгөн сангийн үлдэгдэлд тооллого хийсэн боловч тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх оны огноотой анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж 8,482.2 мянган төгрөгийг бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө*”, 20 дугаар зүйл 20.2.3. “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*" гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, тасалбар болголт, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жижиг мөнгөн сангийн эд хариуцагчийн тайланг хүлээн авч, хяналт хийж, бүртгэлд тусгахдаа анхан шатны үнэн зөв, иж бүрэн баримтыг үндэслэн бүртгэлд тусгах, үлдэгдлийг тоолсон тохиолдолд заавал тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулж, үр дүнг тайланд илэрхийлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1. Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | ЭМЯ-аас өмнөх тушаал шийдвэрээ шинэчлэн гаргахдаа зарим нэр төрлийн нэгж үнэд өөрчлөлт оруулсан, ЭМС-ын тушаалаар нэмж орлого авсан. | | 1 | 152,689.6 | 1 | 152,689.6 | | | | | | | | |
| 2 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Амбулаторийн эмийн сангийн материалын товчоо тайланд 73 ширхэг эмийн үлдэгдлийг 303.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | | 1 | 303.9 | 1 | 303.9 | | | | | | | | |
| 3 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | ЭМДЕГ-аас 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн тулган баталгаажуулалтын хариу захидалд өмнө нь тусламж үйлчилгээний орлогын баталгаажуулсан авлагын үлдэгдлийг 202,946.9 мянган төгрөгөөр хасалт хийж тайлагнасан. | | 1 | 202,946.9 | 1 | 202,946.9 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Үйлчлүүлэгчид олгох 650.6 мянган төгрөгийн эмийг олгоогүй, зардалд бүртгэсэн, үйлчилгээ аваагүй үйлчлүүлэгчдийн үйлчилгээний төлбөрийг буцаахдаа үнийн дүнгээс 754.1 мянган төгрөгийн суутгал хийсэн байна | Буруутай албан тушаалтнаар төлүүлэх, төлбөрийн акт тогтоолоо. | 1 | 1,404.6 | | | 1 | 1,404.6 | | | | | | |
| 5 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Худалдан авалтын гэрээний биелэлт, хэрэгжилтийг тулган шалгахад гэрээний 92.1 хувийг дүгнээгүй, 99,018.0 мянган төгрөгийн 3 гэрээний нийлүүлэлт хийгдээгүй, 59,248.7 мянган төгрөгийн 7 гэрээ бүрэн биелээгүй байхад биелснээр акт үйлдсэн, 130,866.9 мянган төгрөгийн 26 гэрээ бүрэн хэрэгжээгүй, 51,419.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх 7 гэрээний дүнгээс илүү нийлүүлэлт хийсэн нийт 43 гэрээний хэрэгжилттэй холбоотой, 340,552.6 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 9,432.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ гэрээний үнээс өндөр үнээр болон үнийн санал тусгасан үйлдвэрлэгч улс, нэгж үнийг зөрүүтэй гэрээ байгуулан худалдан авалт хийсэн. | Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв. | 1 | 349,984.6 | | | | | 1 | 349,984.6 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, төсөв төлөвлөлтийг эдийн засгийн албанаас бүрэн бэлтгэж төлөвлөөгүй, мэдээлэл дутагдалтай, эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрт дотоод аудит болон дотоод хяналтын талаар тусгагдсан, авсан арга хэмжээний талаар тэмдэглэсэн зүйл байхгүй. | НББ-н тухай хуулийн 19 дүгээр зүйл. 19.1, Төсвийн тухай хуулийн 16.5.6, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус мөрдөж ажиллах. | 1 | | | | | | | | | | 1 | |
| 7 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | ЭМДЕГ-ын санхүүжилтийг нэхэмжилсэн дүнтэй тулган шалгахад 2,824,626.0 мянган төгрөгийн орлого баталгаажаагүй хасагдсан байна. | Өвчтөний оношийг тогтоолын дагуу тавьж, тусламж үйлчилгээ үзүүлсэн зардлыг цахим мэдээллийн санд үнэн зөв мэдээлэн, нэхэмжилж, төлбөр тооцоог тухай бүр нь тулган баталгаажуулж, акт үйлдэж байх. | 1 | | | | | | | | | | 1 | |
| 8 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Алсын дуудлагын томилолтыг түүвэрлэн давтан тооцоолол хийхэд албан томилолтын хуудсанд бичигдсэн ирсэн, явсан хоногийг тооцохдоо 1 хоног хасаагүй, ирсэн явсан өдрийг засварласан, дуудлагын хуудсанд бичигдсэн огноо зөрүүтэй, зарим үед хоногийг дутуу тооцсон. | Мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулж, анхан шатны үнэн зөв баримтад үндэслэн гүйцэтгэлийг хянаж, үр дүнг тооцож байх. | 1 | 864.0 | | | | | | | | | 1 | 864.0 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Жижиг мөнгөн сангийн тайланд худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэргүй баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, үлдэгдэлд тооллого хийсэн боловч тооцоо бодож, баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх оны огноотой анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж бүртгэлд тусгасан байна. | Анхан шатны үнэн зөв, иж бүрэн баримтыг үндэслэн бүртгэлд тусгах, үлдэгдлийг тоолсон тохиолдолд заавал тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулж, үр дүнг тайланд тусгаж байх. | 1 | 8,482.2 | | | | | | | | | 1 | 8,482.2 |
| | | | **Нийт дүн** | | **9** | **716,675.8** | **3** | **355,940.4** | **1** | **1,404.6** | **1** | **349,984.6** | **0** | **0.0** | **4** | **9,346.2** |
| 2. Нийцлийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, шилэн дансанд байршуулах мэдээллийг тулган шалгахад зарим гүйлгээг хугацаа хоцроосон байна. | Ил тод байдлыг хангаж, мэдээллүүдийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх. | | | | | | | | | | | | |
| 2 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | ТУЗ нь хамт олны төлөөлөх гишүүний албан тушаал өөрчлөгдсөнтэй холбогдуулан хамт олныг төлөөлөх гишүүнээс чөлөөлж, шинэ гишүүнийг томилох ажлыг зохион байгуулж ажиллаагүй. | Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцэд өөрчлөлт оруулах ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж, хамт олныг төлөөлөх гишүүнийг шинэчлэн томилох. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | УНТЭ | АХГ-2022/370/НА-СТА-ТШЗ | Эмнэлгийн ахлах нягтлан бодогч бөгөөд санхүүгийн албаны дарга нь Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байна гэсэн шалгуурыг хангахгүй байна. | Ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур, шаардлагыг хангаж ажиллах. | | | | | | | | | | | | |
| | | | **Нийт дүн** | | **9** | **716,675.8** | **3** | **355,940.4** | **1** | **1,404.6** | **1** | **349,984.6** | **0** | **0.0** | **4** | **9,346.2** |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 №32/А015005Ч Улаанбаатар хот
АХГ- 2020/370/НА-СТА-ТНЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Үйлчлүүлэгчид олгох 650,561.23 төгрөгийн эмийг олгоогүй, зардалд бүртгэсэн, үйлчилгээ аваагүй үйлчлүүлэгчдийн үйлчилгээний төлбөрийг буцаахдаа үнийн дүнгээс 754,080.00 төгрөгийн суутгал хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.2.4 "*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*", 20.2.11 "*өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах*", Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 дугаар тушаалын гуравдугаар хавсралт "*Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам*"-ын 2.3 "*Иргэн өөрийн хүсэлтээр нэмэлт тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, алдангигүйгээр буцаан олгож баримтжуулна*" гэсэн заалтуудыг зөрчиж, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийт 1,404,641.23 (Нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга зургаан зуун дөчин нэгэн төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хишигжаргал, Санхүү, бүртгэлийн албаны дарга Б.Банзрагч нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Г.ГҮНЖИДМАА |
| ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Т.МЯГМАРСҮРЭН |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 203/А015 0054 Улаанбаатар хот
АХГ-2022/370/НА-СТА-ПШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Худалдан авалтын 148 гэрээний 92.1 хувийг дүгнээгүй, 99,018,000.00 төгрөгийн 3 гэрээний нийлүүлэлт хийгдээгүй, 59,248,700.00 төгрөгийн 7 гэрээ бүрэн биелээгүй байхад биелснээр акт үйлдсэн, 130,866,863.00 төгрөгийн 26 гэрээ бүрэн хэрэгжээгүй, 51,419,000.00 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх 7 гэрээний дүнгээс илүү нийлүүлэлт хийсэн зэрэг нийт 43 гэрээний хэрэгжилттэй холбоотой 340,552,563.00 төгрөгийн зөрчил илэрсэн.

Харьцуулалтын аргаар 9,432,000.00 төгрөгийн худалдан авалт хийхдээ гэрээний үнээс өндөр үнээр болон үнийн саналд тусгасан үйлдвэрлэгч улс, нэгж үнийг зөрүүлэн гэрээ байгуулан худалдан авалт хийсэн, гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*", гэрээний 2.5, 2.6, 2.8 дугаар заалтуудыг болон УСНББОУС-24, УСНББОУС-32 мөрдөж ажиллаагүй.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 "*энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх*", 49 дүгээр зүйл 49.2.10 "*гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг*" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*" Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Худалдан авалтын гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, үр дүнг тайланд тусгах, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээнд заасан хариуцлага тооцож байх, гэрээний дагуу худалдан авалт хийх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хишигжаргал, ерөнхий нягтлан бодогч Б.Банзрагч нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.МЯГМАРСҮРЭН

# ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ